



ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛ,
СТАТИСТИКИЙН ГАЗРЫН СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙ



2016 он

1.Танилцуулга, судалгааны зорилго

2. Агуулга:

1-р бүлэг: Малтай өрх, малчдын тоо, тэдний соёл ахуйн үзүүлэлтүүд

1.1 Малтай өрх, малчдын тоо, малчин өрхийн тооны өөрчлөлт

1.2 Малчдын насны бүрэлдэхүүн

1.3 Малчдын соёл ахуйн үзүүлэлтүүд

2-р бүлэг: Малын тоо, бүтэц

2.1 Малын тоо

2.2 Хувийн малын тоо

2.3 Хээлтэгч мал

2.4 Төл бойжилт

2.5 Том малын зүй бус хорогдол

2.6 Малын хээл хаялт, сувайралт

2.7 Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироо

3-р бүлэг: Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж

3.1 Бэлчээрийн хүрэлцээ

3.2 Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж

3.3 Малын хашаа, худаг ус цэгийн тоо

4-р бүлэг: Тэжээвэр амьтад

5-р бүлэг: Газар тариалангийн үйлдвэрлэл

3. Нэр томъёоны тайлбар

4. Дүгнэлт

5.Судалгааны хамрах хүрээ

6.Мэдээллийн эх үүсвэр

Судалгааны зорилго:

Аймгийн эдийн засагт Хөдөө аж ахуйн салбарын эзлэх байр суурь, цаашдын хандлагыг тодорхойлоход судалгааны зорилго оршино.

Судалгааны агуулга:

Судалгааг Хөдөө аж ахуйн 2 дэд салбараар хийж, дэд салбар бүрт өнөөгийн байдлыг судалж, өсөлт өөрчлөлт, хувь хэмжээг тодорхойлохыг зорив.

Энэ зорилгоор мал аж ахуйн салбарын ирээдүйн хөгжил, малчдын амьжиргааны талаар бодлого, малын тооны өсөлт өөрчлөлт, бүтэц, малын төллөлт, үржлийн байдал, зүй бус хорогдол, сувайралт хээл хаялт, бэлчээрийн даац хүрэлцээ, тэжээвэр амьтад, хээлтэгч, хээлтүүлэгч, түүний тохироо болон малтай өрх, малчдын нийгмийн байдал, малын тооны өсөлт бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүдийг тодорхойлох, газар тариалангийн салбарын хувьд тариалалт, ургац хураалт, 1га-гийн ургацыг өмнөх онтой харьцуулан судалж, гадны аймагт тариалсан талбай болон ургацын хэмжээг тооцож, аймгийн дүнд эзлэх хувь хэмжээг тогтоов.

1-р бүлэг: Малтай өрх, малчдын тоо, тэдний соёл ахуйн үзүүлэлтүүд


2015 онд 1081 малтай өрх үүнээс 765 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж, үүнд 1364 малчид ажиллаж байна. Малтай өрх өмнөх оноос 42-оор, малчин өрхийн тоо 48-аар, малчдын тоо 74-өөр өсчээ.

1-1. Өрх, малчдын тоо, насны бүтэц

хүснэгт-1

	Хэмжих нэгж	2014	2015	2015/2014	
				Хувь	Зөрүү
Малтай өрх	тоо	1039	1081	104.0	42
Үүнээс: малчин өрх	тоо	717	765	106.7	48
Малчдын тоо	тоо	1290	1364	105.7	74
Үүнээс: 16-34 насны	хүн	263	267	101.5	4
35 ба 60 нас хүртэл	хүн	783	858	109.6	75
Тэтгэвэрийн насны	хүн	244	239	98.0	-5
Нийт малчдаас эмэгтэй	хүн	608	640	105.3	32
Насны бүтэц %	%	100.0	100.0	100.0	0
Үүнээс: 16-34 насны	%	20.4	19.6	96.0	-1
35 ба 60 нас хүртэл	%	60.7	62.9	103.6	2
Тэтгэвэрийн насны	%	18.9	17.5	92.6	-1
Нэг малчин өрхөд ногдох малын тоо*		172	157	91.1	-15

Зураг 1. Өрхийн тоон өөрчлөлт



Аймгийн хэмжээний нийт өрхийн 4.2 хувь нь малтай өрх бөгөөд энэ нь 2014 оноос 0.2 пунктээр нэмэгдсэн байна. Малчдын 46.9 хувь нь эмэгтэйчүүд ба нийт малчдын 19.6 хувь нь 16-34 насны, 62.9 хувь нь 35-60 насны, 17.5 хувь нь тэтгэвэрийн насны хүмүүс байна.

1-2. Малчдын соёл ахуйн үзүүлэлт

Хүснэгт-2.

	Өрхийн тоо		Малчин өрхийн тоонд эзлэх хувь	
	2014	2015	2014	2015
Цахилгаантай	717	765	100.0	100.0
Телевизортой	605	723	84.4	94.5
Автомашинтай	232	331	32.4	43.3
Мотоциклтой	230	243	32.1	31.8
Трактортой	29	55	4.0	7.2

2015 оны тооллогоор бүх малчин өрх цахилгааны эх үүсвэртэй бол 94.5 хувь нь телевизортой, 43.3 хувь нь автомашинтай, 31.8 хувь нь мотоциклтой, 7.2 хувь нь трактортой байна. 2014 оныхоос мотоциклтой өрхийн тоо 5.6 хувиар, телевизортой өрхийн тоо 19.5 хувиар, авто машинтай өрхийн тоо 42.7 хувиар, трактортой өрхийн тоо 89.6 хувиар их, цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо мөн үеийн түвшинд байна.


2-р бүлэг: Малын тоо, бүтэц

2-1. Нийт малын тооны өсөлт өөрчлөлт

хүснэгт-3

	2014	2015	2015/2014	
			Хувь	Зөрүү
Тэмээ	61	21	34.4	-40
Адуу	9127	9127	100.0	0
Үхэр	18177	19188	105.6	1011
Хонь	51233	48110	93.9	-3123
Ямаа	44604	43304	97.1	-1300
Дүн	123202	119750	97.2	-3452

Зураг 2. Нийт малын тоо



2015 онд өмнөх оноос нийт малын тоо 2.8 хувиар буюу 3.4 мянган толгойгоор буурсанаас хонь 3.1 мянган толгойгоор, ямаа 1.3 мянган толгойгоор, үхэр 1.0 мянган толгойгоор, тэмээ 40 толгойгоор буурсан байна. Харин адууны тоо толгой өмнөх оны түвшинд байна. Нийт малын


0.02 хувийг тэмээ, 7.6 хувийг адуу, 16.0 хувийг үхэр, 36.2 хувийг ямаа, 40.2 хувийг хонь эзэлж байна.

2.2 Малын тооны өсөлт бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд

хүснэгт-4

	Хэмжих нэгж	2014	2015	2015/2014	
				Хувь	Зөрүү
Бойжуулсан төл	тол	40076	48073	120.0	7997
100 эхээс бойжуулсан төл	тол	71	88	123.9	17
Том малын зүй бус хорогдол	тол	631	827	131.1	196
Хээлтэгч малын тоо	тол	54853	55207	100.6	354
Хээл хаясан хээлтэгч	тол	598	834	139.5	236
Сувайрсан хээлтэгч	тол	3078	5667	184.1	2589

Зураг 3. Төл бойжилт



2015 оны байдлаар 48073 төл бойжуулсан нь өмнөх оноос 20.0 хувиар буюу 7997 төлөөр, малын зүй бус хорогдол 31.1 хувиар буюу 0.2 мянган толгойгоор, том хээл хаясан хээлтэгч 39.5 хувиар буюу 0.2 мянган толгойгоор, сувайрсан хээлтэгч 84.1 хувиар буюу 2.6 мянган толгойгоор, хээлтэгч мал 0.6 хувиар буюу 0.3 мянган толгойгоор, 100 эхээс бойжуулсан төл нь 23.9


хувиар буюу 17 төлөөр өсчээ.

2.3 Хувийн малтай өрх, малын тоо

Хүснэгт 5

	Малтай өрхийн тоо	Бүгд	Үүнээс					Малтай нэг өрхөд ногдож буй малын тоо
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	
2014	1039	118227	61	8839	17723	47904	43700	114
2015	1081	114876	21	8805	18780	44870	42400	106
Нийт малд эзлэх хувь		95.9	100.0	96.5	97.9	93.3	97.9	-

зураг 4. Хувийн малын тоо




2015 онд иргэдийн хувийн малын тоо 114.8 мянган толгойд хүрч нийт мал сүргийн 95.9 хувийг эзэлж байна. Малтай нэг өрхийн дундаж малын тоо 106 ба өмнөх оноос 8 толгойгоор багасчээ. Бүлэглэлтийн хувьд 101-200 малтай нэг өрхөд

дундажаар 140 толгой, 201-500 малтай нэг өрхөд 322 толгой, 501-999 малтай нэг өрхөд 655 толгой мал ногдож байна.

Хувийн малын тоо толгой өмнөх оноос 2.8 хувиар буюу 3.3 мянган толгойгоор буурсанаас тэмээ 65.6 хувиар буюу 40 толгойгоор, адуу 0.4 хувиар буюу 34

толгойгоор, хонь 6.3 хувиар буюу 3.0 мянган толгойгоор, ямаа 3.0 хувиар буюу 1.3 мянган толгойгоор буурсан бол үхэр 6.0 хувиар 1.1 мянган толгойгоор өсчээ.

Зураг 5. 2015 оны малтай өрх / малын тооны бүлгээр/




Малтай өрхийн 24.1 хувь нь 10 хүртэлх тооны малтай өрх, 23.2 хувь нь 11-30 хүртэлх тооны малтай өрх, 25.8 хувь нь 51-200 хүртэлх тооны малтай өрх байгаа нь бусдаасаа өндөр байна. 2014 оныхоос 201-500 хүртэл малтай өрхийн тоо 3.1 мянгаар, 101-200 хүртэл малтай өрх 4.6 мянгаар, 31-50 хүртэл малтай өрхийн тоо 1.1 мянгаар багасч, 501-999 хүртэл малтай өрхийн тоо 0.7 мянгаар, 51-100 хүртэл малтай өрхийн тоо 1.4 мянгаар, 1000-1499 хүртэл малтай өрхийн тоо 0.5 мянгаар, 11-30 малтай өрхийн тоо 1.3 мянгаар, 10 хүртэл малтай өрхийн тоо 7-оор өссөн байна.

2.5 Хээлтэгч мал

хүснэгт 6

	2014	2015	2015/2014	
			%	Зөрүү
ДҮН	54853	55394	101.0	541
Ингэ	26	7	26.9	-19
Гүү	2957	2979	100.7	22
Үнээ	7569	8070	106.6	501
Эм хонь	23547	22868	97.1	-679
Эм ямаа	20754	21470	103.4	716

Зураг 6. Хээлтэгч мал



2015 онд 55.4 мянган хээлтэгч мал тоологдсон нь өмнөх оныхоос 1.0 хувиар буюу 0.5 мянган толгойгоор өссөний дотор гүү 0.7 хувиар буюу 22 толгойгоор, эм хонь 6.6 хувиар буюу 0.5 мянган толгойгоор өсч, ингэ 73.1 хувиар буюу 19 толгойгоор, эм ямаа 2.9 хувиар


буюу 0.7 мянган толгойгоор буурчээ. Нийт малын 46.3 хувь нь хээлтэгч мал байгаагийн 0.01 хувь нь ингэ, 2.5 хувь нь гүү, 6.7 хувь нь үнээ, 19.1 хувь нь эм хонь, 17.9 хувь нь эм ямаа байна.

2.6 Төл бойжилт.

Хүснэгт-7

	2014	2015					
		Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	40575	48898	18	2061	6082	21499	19238
Бойжсон төл	40076	48073	18	2024	6029	21179	18823
Бойжилтын хувь	98.8	98.3	100.0	98.2	99.1	98.5	97.8

Зураг 7. Төл мал



2015 онд гарсан төлийн 98.3 хувийг буюу 48.1 мянган толгой төл бойжуулжээ. Бойжуулсан төлийн тоо 2014 оныхоос 7.9 мянган толгойгоор их, төл бойжилтын хувь 0.5 пунктээр бага байна. Гарсан ботгоны 100.0 хувь, унаганы 98.2 хувь, тугалын 99.1 хувь,


хурганы 98.5 хувь, ишигний 97.8 хувийг бойжуулав.

2.7 100 эхээс бойжуулсан төл

Хүснэгт-8

	2014	2015	зөрүү
Ботго	23	69	46
Унага	64	68	4
Тугал	74	80	6
Хурга	73	90	17
Ишиг	68	91	23
Аймгийн дүн	71	88	17

Зураг 8. 100 эхээс бойжуулсан төл



2015 онд аймгийн дунджаар 100 эхээс 88 төл бойжуулсан нь өмнөх оныхоос 17 төлөөр их байна. Үүнээс ботго 46, ишиг 23, хурга 17, тугал 6, унага 4 төлөөр их бойжуулжээ.

2.8 Том малын зүй бус хорогдол


Хүснэгт-9

	2014		2015		2015/2014 =%
	Хорогдсон малын тоо	Оны эхний малд эзлэх хувь	Хорогдсон малын тоо	Оны эхний малд эзлэх хувь	
Бүгд	631	0.5	827	0.7	131.1
Тэмээ	1	1.0	0	0	0.0
Адуу	77	0.8	74	0.8	96.1
Үхэр	109	0.6	208	1.1	190.8
Хонь	241	0.4	258	0.5	107.1
Ямаа	203	0.4	287	0.9	141.4


Оны эхний малын 99.3 хувь нь онд орж, мал онд оролт өмнөх оноос 0.2 пунктээр бага байна. 827 толгой том малын зүй бус хорогдож, өмнөх оноос 31.1

хувиар нэмэгджээ. Нийт хорогдсон малын ихэнх нь буюу 65.9 хувь нь бог мал үүний дотроо ямааны хорогдол их байна.

Зураг 9. Том малын зүй бус хорогдол



Зураг 10. Оны эхний малд эзлэх хувь



2.9 Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироо

а). Хээлтүүлэгч малын тоо

Хүснэгт-10

	Бүгд		Үүнээс: шинээр тавьсан	
	2014	2015	2014	2015
ДҮН	1347	1091	33	7
Буур	4	1	1	0
Азрага	341	350	14	3
Бух	213	216	10	4
Хуц	415	279	7	0
Ухна	374	245	1	0

2015 онд 1091 хээлтүүлэгч мал тоологдож, 2014 оныхоос 19.0 хувиар буюу 256 толгойгоор буурсан байна.

б). Хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо

Хүснэгт-11

	Үржлийн норм	2014	2015
Ингэ	8-10	7	7
Гүү	12-15	9	9
Үнээ	35-45	36	37
Эм хонь	25-30	57	82
Эм ямаа	25-30	55	88

Хуц, ухны үржлийн норм 2.7-2.9 дахин өндөр байхад буур, азарганы хувьд дунджаар 1.4-1.7 дахин доогуур, бухны хувьд үржлийн нормын хэмжээнд хүрч байна.

Хүнсний хэрэглээ

2015 онд оны эхний нийт малын 8.4 хувьтай тэнцэх 10.1 мянга толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. Малыг хэрэглээний зарлага өмнөх оныхоос 47.9 хувиар буюу 3.3 мянган толгойгоор илүү байна.

Хүснэгт 12

Төрөл	2014	2015	Оны эхний малд эзлэх хувь	
			2014	2015
Бүгд	6804	10062	5.5	8.4
Тэмээ	3	2	4.9	9.5
Адуу	190	227	2.1	2.5
Үхэр	914	1278	5.0	6.7
Хонь	3432	4732	6.7	9.8
Ямаа	2265	3823	5.1	8.8

Оны эхний адууны 2.5 хувь, тэмээний 9.5 хувь, үхрийн 6.7 хувь, ямааны 8.8 хувь, хонины 9.8 хувийг хүнсний хэрэглээнд зарцуулсан байна. Хэрэглээнд зарцуулсан малын 15.0 хувийг бод мал, 85.0 хувийг бог мал эзэлж байна.

3-р бүлэг: Малыг бэлчээр, тэжээлийн хүрэлцээ хангамж

3.1 Бэлчээрийн хүрэлцээ хангамж

Хүснэгт-13

	2014	2015	2015/2014=%
Хадлан бэлчээрийн талбай /мянга га/	41.1	41.1	100.0
Нийт малыг хонин толгойд шилжүүлсэн малын тоо	264633	266206	100.6
100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо	644	648	100.6

Хонин толгойд шилжүүлснээр малын тоог 266.2 мянга болж өмнөх оныхоос 0.6 хувиар нэмэгдсэн байна. 100 га хадлан бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 648 байгаа нь өмнөх оныхоос 4 толгойгоор өссөн байна.

3.2 Бэлтгэсэн тэжээл нэр төрлөөр, тонноор

Хүснэгт-14

	2014	2015	2015/2014=%
Хадлан өвс	11304.2	7634.8	67.5
Таримал тэжээл	23.1	0.0	0.0
Даршны ургамал	0.0	46.0	0.0
Гар тэжээл, хужир шүү	332.7	281.1	84.5
Төмс хүнсний ногооны хаягдал	57.0	0.0	0.0
Үр тарианы хаягдал	59.1	0.0	0.0
Лай	0.3	0.0	0.0
Сүрэл	258.5	288.2	111.5
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд (тэж.нэгж шилжүүлсэн)	5558.2	3800.3	68.4

Энэ онд 7.6 мянган тонн өвс, тэжээлийн нэгжид шилжүүлснээр 3800.3 тн тэжээл бэлтгэсэн нь өмнөх оноос 31.6%-иар буурсан байна.

Өмнөх онд таримал тэжээл тариалсан бол энэ онд даршны ургамал тариалж 46 тн-ыг хураан авсан байна.


3.3 Тэжээл хангамж

хүснэгт-15

	2014	2015	зөрүү
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд (тэж.нэгж шилжүүлсэн)	5558.2	3800.3	-1757.9
Нийт малыг хонин толгойд шилжүүлсэн /Мянган тол/	264.6	266.2	1.6
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, тэж.нэгж, кг	21.0	14.3	-6.7

2015 онд хонин толгойд шилжүүлсэн нэг малд 14.3 кг тэжээл ногдож байгаа нь 2014 оныхоос 6.7 кг-аар бага байна.

Зураг 11. Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ноогдох тэжээл, нэгж, кг



4-р бүлэг. Тэжээвэр амьтад

Хүснэгт-16

	Өсгөн үржүүлдэг аж ахуйн тоо		Тэжээвэр амьтдын тоо		2015/2014	
	2014	2015	2014	2015	Хувь	Зөрүү
Гахай	3		667	576	86.4	-91
Шувуу			1215	2285	188.1	1070
Илжиг			2	0	0.0	-2
Зөгий (бүл)			91	301	330.8	210
Туулай			41	126	307.3	85

2015 онд 576 гахай, 2285 шувуу, 301 зөгийн бүл, 126 туулай тоологдож өмнөх оныхоос шувуу 1070-аар, зөгий 210 бүлээр, туулай 85-аар өсч, гахай 91-ээр, илжиг 2-оор буурсан байна.

4.1 Мал эмнэлэгийн үйлчилгээ

Хүснэгт-17

1	Үзүүлэлт	2014	2015	2015/2014=%
1	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан мал амьтад	171391	174551	101.8
2	Туулгалт хийсэн бүх мал амьтад / тол /	168918	150335	89.0
3	Боловсруулалт хийсэн бүх мал амьтад / тол /	164668	137572	83.5
4	Паразит өвчнөөр өвчилсөн бүх мал амьтад /тол /	26423	33377	126.3
5	Үүнээс хорогдсон мал амьтад / тол /	23	15	65.2
6	Халдварт өвчнөөр өвчилсөн бүх мал амьтад /тол /	29	44	151.7
7	Үүнээс хорогдсон мал амьтад / тол /	9	39	433.3
8	Үзлэг хийсэн мал амьтад / тол /	225563	250405	111.0
9	Угаалганд хамруулсан мал амьтад	93530	58914	63.0

Аймгийн хэмжээнд 8 мал эмнэлэг ажиллаж давхардсан тоогоор 250.4 мянган толгой мал, тэжээвэр амьтанд үзлэг хийж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 174.6 мянган толгой малыг хамруулсан нь өмнөх оноос 11.0-1.8 хувиар өсчээ.

5. Худаг, уст цэг

Хүснэгт-18

Он	Сумын нэр	Бэлэн байгаа нийт худгийн тоо	Үүнээс		Хувийн аж ахуйн	Нийт худгаас				Усан сан			
			инженерийн	Энгийн, уурхайн		Бэлчээрт байршдаг	ашиглагдаагүй	Шинээр ашиглалтанд оруулсан	Сэргэн засварласан	тоо	Багтамж /м/м3 /	Үүнээс шинээр ашиглалтанд оруулсан	Сэргэн засварласан
2014	Баян-Өндөр	122	86	36	45	35	4	3	4	43	270.2	0	0
	Жаргалант	122	61	61	61	38	16	1	3	2	9.6	0	0

	Аймгийн дүн	244	147	97	106	73	20	4	7	45	279.8	0	0
2015	Баян-Өндөр	125	89	36	45	38	8	0	1	43	270.2	0	0
	Жаргалант	114	54	60	60	41	13	0	2	2	9.6	0	0
	Аймгийн дүн	239	143	96	105	79	21	0	3	45	279.8	0	0
2015/2014=%		98.4	97.3	99.0	99.1	108.2	105.0	0.0	42.9	100.0	100.0	0.0	0.0

Аймгийн хэмжээнд бэлэн байгаа нийт худгийн тоо 239 болж, өмнөх оноос 5-аар багасчээ. Нийт худгийн 79 нь буюу 33.1 хувь нь бэлчээрт байршдаг, ашиглагддаггүй 21 худаг байна. 2015 онд 3 худгийг сэргээн засварлажээ. 279.8 куб.метр багтаамжтай 45 усан сан байна.

5-р бүлэг: Газар тариалангийн үйлдвэрлэл

Жилийн дунджаар хөдөө аж ахуйн нийт үйлдвэрлэлтийн 40.2 хувийг газар тариалангийн салбар эзэлдэг ба газар тариалан эрхлэлтийн 49.1 хувийг гадны аймгийн нутаг дэвсгэрт явуулж байна. Үүнээс 11 ААН, 44 иргэн Булган аймгийн Бугат, Хутаг-Өндөр, Хангал суманд, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд тариалалт хийж, нийт үр тарианы 54.2 хувь буюу 2160.4 тн, төмсний 17.2 хувь буюу 469.3 тн, хүнсний ногооны 13.6 хувь буюу 370.1 тн-ыг эдгээр аймгийн нутаг дэвсгэрт тариалж ургац авсан байна.

Хүнсний ногооны 36.1 хувь байцаа, 30.4 хувь манжин, 27.5 хувь лууван, 3.6 хувь сонгино, 1.9 хувь өргөст хэмх, 0.1 хувь улаан лооль, 0.4 хувийг бусад нарийн ногоо эзэлж байна.

Тариалсан талбайн хэмжээг 2014 оныхтой харьцуулахад үр тарианы талбай 12.2 хувиар өсч, төмсний талбай 23.0 хувиар, хүнсний ногооны талбай 6.6 хувиар, ургацын хувьд үр тариа 6916.7 тн-оор, хүнсний ногоо 1732.8 тн-оор, төмс 686.2 тн-оор буурсан байна.

Тариалсан талбайн хэмжээ, га

		Хүснэгт 19	
		2014	2015
Тариалалт эрхэлсэн өрхийн тоо		954	665
Нийт тариалсан талбай		4532.6	4693.9
Үүнээс:	Үр тариа	3578.1	4014.5
	Төмс	332.5	255.9
	Хүнсний ногоо	279.4	261.0
	Техникийн ургамал /рапс/	158.0	45.0

Жимс, жимсгэнэ	19.7	1.5
----------------	------	-----

Нийт тариалсан талбайн 85.5 хувь буюу 4.9 мянган га тайлбайд үр тариа, 5.4 хувь буюу 255.9 га талбайд төмс, 5.6 хувь буюу 261.0 га талбайд хүнсний ногоо, 1.0 хувь буюу 45.0 га талбайд техникийн ургамал, 0.03 хувь буюу 1.5 га талбайд жимс жимсгэнэ тариалсан нь өмнөх оныхоос нийт тариалсан талбай 3.6 хувь буюу 161.3 га-гаар нэмэгдсэн байна.


Хураасан ургац, тонн

Хүснэгт 20

		2014	2015
Хураасан ургац		15474.3	10209.1
Үүнээс:	Үр тариа	11867.1	4950.4
	Төмс	3199.8	2513.6
	Хүнсний ногоо	4477.9	2745.1
	Техникийн ургамал /рапс/	115.0	0

2015 онд нийт 10.2 мян.т ургац хурааж авсанаас 4.9 мян.т үр тариа, 2.5 мян.т төмс, 2.7 мян.т хүнсний ногоо хураан авсан байна. Өмнөх оныхоос үр тариа 6916.7 мян.т буюу 58.3 хувиар, хүнсний ногоо 1.7 мян.т буюу 38.7 хувиар, төмс 686.2 тн буюу 21.4 хувиар буурчээ.

Зураг12. Хураан авсан ургац



1 ГА-ИЙН УРГАЦ

Хүснэгт.21

	Хэмжих нэгж	Улсын дундаж		Орхон аймаг	
		2014	2015	2014	2015
Үр тариа	центнер	16.5	5.5	33.2	14.2
Төмс	центнер	122.3	127.5	96.2	100.6
Хүнсний ногоо	центнер	120.9	94.5	160.3	112.9

Нэг га-гаас дунджаар 2015 онд 14.2 цн үр тариа, 100.6 цн төмс, 112.9 цн хүнсний ногоо хураан авсан бөгөөд нэг га-гаас авсан ургац өмнөх оныхоос хүнсний ногооных 47.4 цн, үр тарианых 19.0 цн-ээр багасч, төмснийх 4.4 цн-ээр нэмэгджээ.

2015 онд 1 га-аас хураан авсан үр тариа улсын дунджаас 8.7 цн-ээр, хүнсний ногоо 18.4 цн-ээр их, харин төмс 26.9 цн-ээр бага байна.

Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт:

Малтай өрх. Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх.

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амжиргааны эх үүсвэр болж байгаа өрх.

Малчид. Малчин өрхийн 16 ба түүнээс дээш насны гишүүд

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хамруулна.

Тэмээ-4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу-3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр-2 настай, 3 ба түүнээс дээш настай

Хонь -тухайн жилийн төл малаас бусад насны мал

Ямаа-тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал.

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3настай

Адуу-Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр-Өнгөрсөн жилийн төл

Төл мал. Тухайн жилд гарсан төл.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт, зарлага тал нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан, 100-гаар үржүүлнэ.

Том малын зүй бус хорогдолд. өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулага, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Дүгнэлт

Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн үзүүлэлтээр манай аймаг улсын хэмжээнд харьцангуй бага хувийг эзэлдэг ба энэ нь газар нутаг багатайн дээр уул уурхайд түшиглэсэн хотжилт түлхүү хөгжсөнтэй холбоотой.

Мал аж ахуй

2015 оны байдлаар аймгийн хэмжээнд 765 малчин өрхийн 1364 малчин мал аж ахуй эрхэлж байна. Малчдын соёл ахуйн үзүүлэлтийн өсөлтөөс харахад аж амьдрал, ахуйн хэрэгцээ нилээд сайжирсан байна. Тухайлбал зарим өрх 2 төрлийн цахилгааны үүсгүүртэй, дийлэнх өрх нь телевизортой байгаа нь үүнийг нотолж байна.

2015 онд малчин өрхүүд 119.8 мянган толгой мал тоолуулсан нь өмнөх оныхоос 3.4 мянган толгойгоор буюу 2.8 хувиар багасчээ.

Тухайлбал: Малын төрлөөр авч үзвэл тэмээ 65.6 хувь буюу 40 толгойгоор, хонь 6.1 хувь буюу 3.1 мянган толгойгоор, ямаа 2.9 хувь буюу 1.3 мянган толгойгоор буурсан байна.

Том малын зүй бус хорогдол өмнөх оноос 31.1 хувиар нэмэгдсэн ба нийт хорогдлын 34.7 хувь нь ямаа, 31.2 хувь нь хонь, 25.1 хувь нь үхэр, 8.9 хувь нь адуу байна.

55.4 мянган хээлтэгч мал тоологдсон нь нийт малын 46.3 хувийг эзэлж, өнгөрсөн оноос хээлтэгчийн тоо 1.0 хувь буюу 541 толгойгоор өсчээ. Нийт малд хээлтэгчийн эзлэх хувийн жин 2014 оныхоос 1.8 пунктээр, 100 эхээс бойжуулсан төлийн тоо 17 толгойгоор өсчээ.

Малын үржлийн нормоор үнээнээс бусад малын төрөл дээр хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо алдагдсан байна. (хүснэгт 11) Энэ байдал жилийн жилд гардаг үзэгдэл бөгөөд энэ нь мал үржлийн ажлыг бодлогоор зохицуулж хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Мал сүргийн 80.0 гаруй хувь нь бог мал, бог малын дийлэнхи нь хонин сүрэг, бог малын дийлэнхи нь үхэр сүрэг ба аймгийн малын бүтцэд бог малын эзлэх хувийн жин өсөх хандлага жил бүр хадгалагдаж байна.

Бэлчээрийн талбай хүрэлцэхгүйгээс хонин толгойд шилжүүлсэн 100 га хадлан бэлчээрийн талбайд ногдох малын тоо, улсын дунджаас 8.3 дахин их байна. Энэ нь малын өсөлт, тарга хүчинд сөрөг нөлөөлтэйгээс гадна. Ер нь манай аймагт бэлчээрийн мал аж ахуй хөгжих боломжгүй, бөгөөд энэ нь эрчимжсэн

байран маллагаатай фермерийн цөөн тооны аж ахуй байх нь зохистойг харуулна. Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл өмнөх оныхоос 6.7 кг-аар бага байна.

Газар тариалан

Газар тариалангийн салбарт 2015 онд аймгийн хэмжээнд 4.7 мянган га талбайд 20 аж ахуйн нэгж, 665 өрх тариалалт хийж иргэд 4014.5 га-гаас 4950.4 тн үр тариа, 255.9 га-аас 2513.6 тн төмс, 261.0 га-аас 2745.1 тн хүнсний ногоо хураан авчээ. Тариалсан талбайн 1 га-аас 14.2 цн үр тариа, 100.6 цн төмс, 112.9 цн хүнсний ногоо хураасан нь ургац тогтоолтын балансаас хүнсний ногоо 32.0 цн-ээр, үр тариа 2.3 цн-ээр, төмс 23.2 цн-ээр их байна.

Энэ жил цаг агаарын байдал гантай байснаар хураасан ургацын хэмжээ 34.0 хувиар багасчээ. Өөрөөр хэлбэл өмнөх оноос нэг га-аас хураан авсан төмс 0.7 дахин, үр тариа 0.4 дахин, хүнсний ногоо 0.6 дахин багасчээ.

Аймагт газар тариалангийн хэмжээ бага, тариалангийн талбай хүрэлцдэггүйгээс хөрш, зэргэлдээ аймгийн газар нутагт тариалалт хийдэг аж ахуйн нэгж, иргэд цөөнгүй байдаг. Жилд дунджаар 10-аад ААНБ, 40 гаруй өрх, иргэд гадны аймгийн нутаг дэвсгэрт газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг нь үүнийг нотолно.

Судалгааны хамрах хугацаа:

2014 - 2015 он

Зарим диаграмм зургийг өмнөх 5-н жилээр гаргав.

Мэдээллийн эх үүсвэр:

- 2014-2015 оны жилийн эцсийн мал тооллогын материал
- 2015 оны улсын статистикийн эмхэтгэл
- Статистикийн шинжилгээ судалгаа хийх арга зүйн зөвлөмж /Аймаг, дүүргийн статистикийн хэлтсийн ажилтнуудад зориулав/

Нóààèãàà òèéñýí : Ажилтан Б.Золзаяа

2016-03-18